



Товчилсон үгийн тайлбар

УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний Аудитын газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
АИТХ	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
АЗДТГ	Аймгийн Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
БОАЖГ	Байгал орчин, аялал жуулчлалын газар
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
ХГБХХ	Хүүхэд гэр бүл, хөгжлийн хэлтэс
НХС	Нийгмийн халамжийн сан
ХААА	Худалдан авах ажиллагааны алба
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ХБХ	Хөгжлийн бодлогын хэлтэс
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
УНС	Улсын нөөцийн салбар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
СТАУС	Санхүүгийн тйалангийн удирдлагын систем
ХОМ	Хөрөнгө орлогын мэдүүлэг

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА ТӨВ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН 2016 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2016 оны 07 дугаар сарын 07

Зуунмод

Нэг. Удирдлага зохион байгуулалтын талаар

Үндэсний аудитын газрын харьяа Төв аймгийн Аудитын газар нь 2016 оны эхний хагас жилд Монгол Улсын Төрийн аудитын тухай хууль болон бусад хууль тогтоомжийг удирдлага болгон аудитын олон улсын стандартын хүрээнд үйл ажиллагаагаа явууллаа.

Төв аймгийн Аудитын газар нь 2016 оны аудитын болон үйл ажиллагааны төлөвлөгөөг 7 бүлэг 44 хэрэгжүүлэх арга хэмжээтэйгээр боловсруулан аудитор, шинжээч нарын үр дүнгийн гэрээнд тусгуулан хэрэгжилтийг улирал, хагас жилээр тооцон ажиллаа. Эхний хагас жилд хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг бүрэн хэрэгжүүлэн ажиллаа.

Аймгийн Аудитын газарт дарга, тэргүүлэх аудитор, менежер, гүйцэтгэлийн аудитын гурван ажилтан, санхүүгийн аудитын хоёр багтай, бусад ажилтан хоёр байхаар зохион байгуулан ажиллаж байна. 2016 онд 14 үндсэн орон тоо батлагдсаны дагуу нийт 1256 хүн/өдөр ажилласан байна.

2016 оны эхний хагас жилд 3 гүйцэтгэлийн аудит, 3 нийцлийн аудит, 280 санхүүгийн аудитыг хийж, 37250.2 сая төгрөгийн зөрчил илэрүүлж, 10870.2 сая төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулж, 634.8 сая төгрөгийн төлбөрийн акт, 17303.8 сая төгрөгийн албан шаардлага бичиж, 514 зөвлөмж өгч, 117.3 сая төгрөгийг орон нутгийн төсөвт орууллаа. Актын барагдуулалт 21.8 хувийн биелэлттэй, албан шаардлагын хэрэгжилт 70.1 хувийн биелэлттэй байна.

Нийт санхүүгийн үр өгөөж 1978.0 сая төгрөг бүртгэж, харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрөгдсөн санхүүгийн үр өгөөж 586.7 сая төгрөг байна.

Хоёр. Санхүүгийн аудитын талаар

2.1 Санхүүгийн аудитын талаар

Төсвийн байгууллагууд болон ТБОНӨААН-ийн санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Аймгийн аудитын газар нь Үндэсний аудитын газраас 2014 онд нэвтрүүлж эхэлсэн Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын систем (СТАУС) программыг 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийхэд бүрэн ашиглалаа. Санхүүгийн аудитад уг программыг ашигласнаар тодорхой хэмжээгээр цаг хугацаа хэмнэж, хянан удирдах үйл ажиллагааны арга зүйг стандартын дагуу хэрэгжүүллээ.

Сумдын соёлын төвүүд болон ТБОНААН-үүдийн санхүүгийн тайланд Их монгол хүлэг Аудит ХХК, сумдын эрүүл мэндийн төвүүдийн санхүүгийн тайланд Бэстгранд Аудит ХХК, сумдын цэцэрлэгүүдийн санхүүгийн тайланд Эс Эм Аудит ХХК, нийт 92 байгууллагын санхүүгийн тайланд гэрээний дагуу аудитыг гүйцэтгэж, аймгийн Аудитын газрын аудитор, шинжээч нар нь бусад 160 байгууллагуудад аудитыг стандарт, журам, гарын авлага, арга зүйн дагуу хийж 839 хүн/өдөр ажиллаа.

Аудитаар 252 байгууллагад санал дүгнэлт гаргаснаас Алтанбулаг сумын цэцэрлэг, Зуунмод сумын 5-р сургууль, Худалдан авах ажиллагааны алба гэсэн 3 байгууллагад

“Сөрөг” санал дүгнэлт, 29 байгууллага буюу 11.5 хувьд “Хязгаарлалттай” санал дүгнэлт, 220 байгууллага буюу 87.3 хувьд нь “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн байна. Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж зөрчилгүй санал дүгнэлт гаргасан.

Аудитаар нийт 31671.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс аудитын явцад 10870.2 сая төгрөгийн алдааг залруулж, 574.5 сая төгрөгийн төлбөрийн акт, 13428.8 сая төгрөгийн албан шаардлага бичиж, 49 албан тушаалтанд хариуцлага тооцох санал хүргүүлж, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх талаар 494 зөвлөмж хүргүүлсэн байна. Тэргүүлэх аудиторовн тушаалаар акт, албан шаардлага, зөвлөмжийг баталгаажуулан ажиллаа.

Эхний хагас жилд аудитын үйлчилгээний төлбөрөөр 8.1 сая төгрөг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн. Төлбөрийн актын биелэлтээр 109.2 сая төгрөг орон нутгийн төсвийн орлогод төвлөрүүлснийг үр өгөөжөөр хүлээн зөвшөөрч бүртгэлээ.

Эрүүл мэндийн байгууллагуудын санхүүгийн тайланд аудит хийсэн талаар

Төв аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2015 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд 26 сумын Эрүүл мэндийн төв, Хүүхэд залуучуудын соёл спортын Солонго цогцолбор, Биеийн тамир спортын газар, Баруун-Зуунмод өрхийн эмнэлэг нийт 29 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Эрүүл мэндийн салбарын санхүүгийн тайланд гарч буй нийтлэг алдаа зөрчил нь нормативт зардлыг хэтрүүлэн зарцуулсан, бэлтгэн нийлүүлэгч байгууллагын нэхэмжлэхгүйгээр шилжүүлэг хийсэн, хүчин төгөлдөр бус баримтыг үндэслэн бараа материал орлогод авсан, анхан шатны баримтын бүрдэл дутуу, бэлэн мөнгө олгохыг хүссэн өргөдөлгүйгээр гүйлгээ хийсэн, өр авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, бараа материалын тайлангаарх үлдэгдэл жилийн эцсийн тооллогоор бүрэн баталгаажаагүй зэрэг байна.

Боловсролын байгууллагуудын санхүүгийн тайланд аудит хийсэн талаар

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2015 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд Ерөнхий боловсролын сургуулийн 31 байгууллага, СӨБ-ийн 31 байгууллага, Хувийн хэвшлийн 4 цэцэрлэг, 1 сургууль нийт 67 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийгдэхээс хувийн хэвшлийн 5 байгууллага аудитад хамрагдаагүй байна.

Ерөнхий боловсролын сургуулиудаас Аргалант, Баянхангай, Баян, Баянчандмань, Бүрэн, Борнуур, Мөнгөнморьт, Сүмбэр зэрэг 8 сургуульд “хязгаарлалттай” санал дүгнэлт, Зуунмодны 5-р сургуульд “сөрөг” санал дүгнэлт, бусад 20 сургуульд “зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудаас Алтанбулаг сумын цэцэрлэг “сөрөг” дүгнэлт, Баянхангай, Угтаал, Мөнгөнморьтын цэцэрлэгүүдэд “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгч, бусад 28 цэцэрлэгт “Зөрчилгүй” санал дүгнэлт өглөө.

Соёлын байгууллагуудын санхүүгийн тайланд аудит хийсэн талаар

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2015 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд соёлын салбарын 29 байгууллагаас аймгийн театр, номын сан, музей гэсэн 3 шууд захирагчийн санхүүгийн тайланд аймгийн Аудитын газрын аудитор, шинжээч нар, 26 сумын соёлын төвийн байгууллагын санхүүгийн тайланд гэрээний дагуу Их Монгол хүлэг Аудит ХХК аудит хийж дүгнэлт гаргасан. Аудитаар 29 байгууллагаас 26 шууд захирагчийн санхүүгийн тайланд “зөрчилгүй” санал дүгнэлт, Баян-Өнжүүл, Баянхангай, Угтаал сумдын соёлын төвийн санхүүгийн тайланд “хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн.

Аймгийн Засаг даргын байгууллагуудын санхүүгийн тайланд аудит хийсэн талаар

Аймгийн орон нутгийн төсвийн байгууллагуудаас АИТХ, АЗДТГ, 27 сумын ИТХ, ЗДТГ, БОАЖГ, ГХБХБГ, ХГБХХ, НХС, ХААА, Ахмадын чөлөөт холбоо, сумын Ойн анги, Санхүү, хяналт аудитын алба, Хот тохижуулах газар зэрэг 65 байгууллага аудитад бүрэн хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан байгууллагуудаас Баянхангай сумын ИТХ, Баянхангай сумын ЗДТГ, Баянцогт сумын ЗДТГ, Заамар сумын ЗДТГ, Зуунмод сумын ИТХ, Өндөрширээт сумын ЗДТГ, Цээл сумын ИТХ, Эрдэнэсант сумын ЗДТГ зэрэг 8 байгууллагад “Хязгаарлалттай” санал дүгнэлт, Худалдан авах ажиллагааны албанд “Сөрөг” санал дүгнэлт, 56 байгууллагад “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн байна.

Улсын төсвийн байгууллагуудын санхүүгийн тайланд аудит хийсэн талаар

Улсын төсвийн 34 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийж санал, дүгнэлт гаргалаа. 33 байгууллагад “зөрчилгүй” санал дүгнэлт өгч, 1 байгууллагад “хязгаарлалттай” санал дүгнэлт өгч, хязгаарлалттай дүгнэлт авсан Боловсрол, соёлын газрын дарга, нягтлан бодогч нарт хариуцлага тооцуулах санал хүргүүлэн хэрэгжилтийг тооцлоо.

Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуй нэгжүүдийн санхүүгийн тайланд аудит хийсэн талаар

Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуй нэгжүүдийн санхүүгийн тайланд аудит хийж 5 санал, дүгнэлт гаргалаа. 5 байгууллагад “зөрчилгүй” санал дүгнэлт өгч, 1 байгууллага буюу Махны үйлдвэр ОНӨҮГазар нь тайлангаа ирүүлээгүй тул холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар санал хүргүүлээд байна.

2.2 Завсрын аудитын талаар

Эхний хагас жилд орон нутгийн болон улсын төсвийн 16 байгууллагын санхүү, бүртгэл, дотоод хяналтын үйл ажиллагаанд завсрын аудитыг хийлээ. Үүнд: Онцгой байдлын газар, Аймгийн ЗДТГ, Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс, Нийгмийн халамжийн сан, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, Худалдан авах ажиллагааны алба, Ус, цаг уур, орчны шинжилгээний төв, Нэгдсэн эмнэлэг, Хөдөлмөрийн хэлтэс, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Шүүхийн шинжилгээний алба, Татварын хэлтэс, Цагдаагийн газар, Хөдөө аж ахуйн газар, Нийгмийн даатгалын хэлтэс, Нийгмийн даатгалын сан гэсэн байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хийж, илэрсэн алдаа, зөрчлийг залруулах зөвлөмжийг удирдлагуудад нь хүргүүллээ.

Гурав. Гүйцэтгэлийн аудитын талаар

Аймгийн аудитын газрын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу ҮАГазрын нэгдсэн удирдамж, төлөвлөгөөний дагуу эхний хагас жилд 3 гүйцэтгэлийн аудит хийж 259 хүн/өдөр ажиллаа. Гүйцэтгэлийн аудитаар 11.9 сая төгрөгийн төлбөрийн акт, 2531.8 сая төгрөгийн албан шаардлага бичиж, 10 зөвлөмж өгч, 347.1 сая төгрөгийн үр өгөөж тооцлоо.

3.1. Монгол улсын Ерөнхий аудиторын баталсан ҮАГ-ын нэгдсэн төлөвлөгөө, Аймгийн аудитын газрын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу “**Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүн**”-д аудитыг 02 дугаар сарын 01-нээс 04 дүгээр сарын 20 хүртэл хугацаанд хийж гүйцэтгэн тайлан, судалгааг ҮАГ-т хүргүүллээ.

Аудитыг төрийн сангийн харилцах дансны хуулга, санхүүгийн анхан шатны баримт, ХБХ, ХААА-ны ажлын гүйцэтгэл гаргасан мэдээ, тайлан болон худалдан авах

ажиллагаатай холбоотой тендерийн бичиг баримт, ГХБХБГ-ын ажлын гүйцэтгэлийн баримтан дээр тулгуурлан хийж гүйцэтгэлээ.

2015 онд аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 1059.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 хөрөнгө оруулалтад 759.5 сая төгрөг батлагдаж, 759.5 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, бүрэн хэрэгжиж дууссан байна. Мөн аймгийн орон нутгийн төсвийн нийт 4 эх үүсвэрээс 3624.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр аймгийн ИТХ-аар жагсаалтаар баталсан байна. Аймгийн ИТХ-аас 2015 оны төсөвт 2 удаа тодотгол хийж, нийт 3625.0 сая төгрөгийн 54 ажил хийхээр батлагдаж, 40 ажилд 2315.4 сая төгрөгийн санхүүжилтийг олгожээ.

Аудитын явцад төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаа, ажлын гүйцэтгэл, хөрөнгийн данс бүртгэлтэй холбоотой нийт 1475.9 сая төгрөгийн зөрчил илэрч, 11.9 сая төгрөгийн акт, 1464.0 сая төгрөгийн албан шаардлага бичигдэж, холбогдох байгууллага, албан тушаалтнуудад зөрчлийг арилгах 5 зөвлөмжийг хүргүүлсний 69.9 сая төгрөгийн албан шаардлага биелэсэн, бусад акт, албан шаардлагын хэрэгжих хугацаа болоогүй байна.

3.2. Монгол улсын Ерөнхий аудиторын баталсан нэгдсэн төлөвлөгөө, Аймгийн аудитын газрын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу **“Төв аймгийн 2015 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл”** –д аудитыг 2016 оны 05 дугаар сарын 01-нээс 05 дугаар сарын 15-ний хугацаанд хийлээ.

Аймгийн 2015 оны төсвийн орлого, эх үүсвэрийг аймаг, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн хуралдаанаас 69317.8 сая төгрөгөөр баталсан. Аймгийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн гүйцэтгэлийн аудитаар 2015 онд аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хуралдаанаас анхны баталсан төсвийн орлого, эх үүсвэрийн төлөвлөгөөг тайлант хугацааны эцэст орлого, зарлагын гүйцэтгэлд тохируулан 2 удаа өөрчлөн тодотгон баталсан байна.

2015 оны төсвийн нийт орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад өмнөх оноос 2846.7 сая төгрөгөөр буурсан ба тайлант оны батлагдсан төлөвлөгөөнөөс 3713.2 сая төгрөгөөр дутуу санхүүжигдсэн байна. Үүнд:

- ✚ 2015 онд улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэг батлагдсан төлөвлөгөөгөөр 9626.8 сая төгрөг, гүйцэтгэлээр 9358.8 сая төгрөгийг авч 268.0 сая төгрөгөөр
- ✚ ОНХСангийн орлогын шилжүүлэг 4594.2 сая төгрөгөөр батлагдсанаас, гүйцэтгэлээр 3817.0 сая төгрөг санхүүжигдэж, 777.2 сая төгрөгөөр
- ✚ Тусгай зориулалтын шилжүүлэг төлөвлөгөөгөөр 37611.7 сая төгрөг авахаас, гүйцэтгэлээр 36905.4 сая төгрөг авч, 706.3 сая төгрөгөөр тус тус дутуу санхүүжигдсэн байна.

2015 оны аймгийн урсгал төсвийн орлогын нийт төлөвлөгөө 12877.5 сая төгрөг, гүйцэтгэлээр 13042.4 сая төгрөг төвлөрч, орлогын төлөвлөгөөг 101.3 хувиар буюу 164.8 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Аймгийн татварын орлогын төлөвлөгөө нийт дүнгээр 101.3 хувиар биелсэн боловч сумын орон нутгийн төсөвт төвлөрөх орлогын төлөвлөгөөг Аргалант, Баянжаргалан, Баянхангай, Баянцогт, Борнуур, Бүрэн, Дэлгэрхаан, Жаргалант, Заамар, Угтаал, Цээл, Эрдэнэ, Зуунмод сумд 4.3-42.9 хувиар тасалж, аймгийн төвлөрсөн төсвийн орлогын төлөвлөгөөг Архуст, Баянжаргалан, Баянцагаан, Цээл зэрэг сумд нь 14.5-39.0 хувиар тасалсан байна.

Татварын орлогын төлөвлөгөөний биелэлтийг нэр төрлөөр авч үзвэл 9 нэр төрлийн орлого 2.9-52.8 хувиар тасарсан байна.

Аймгийн ТЕЗ-ийн 2015 оны жилийн эцсийн Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар нийт зарлага батлагдсан төлөвлөгөөгөөр 69317.8 сая төгрөг, гүйцэтгэлээр 65148.4 сая төгрөгийг зарцуулж, батлагдсан төлөвлөгөөнөөс 4169.5 сая төгрөг дутуу зарцуулсан буюу биелэлт 93.98 хувь байна. Төсвийн гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулахад 5222.9 сая төгрөгөөр дутуу зарцуулсан байна. Гүйцэтгэлийн аудитаар аймгийн удирдлагад 5 зөвлөмжийг хүргүүлжээ.

3.3. Монгол улсын Ерөнхий аудиторын баталсан нэгдсэн төлөвлөгөө, Аймгийн аудитын газрын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу **“Улсын нөөцийн бүрдүүлэлт, хуваарилалт, зарцуулалтын дүн”** –д аудитыг 2016 оны 04 дугаар сарын 01-нээс 05 дугаар сарын 20-ны хугацаанд хийж Үндэсний аудитын газарт удирдамжийн дагуу судалгаа, тайлбар гарган хүргүүлсэн.

Аудитад Төв аймагт үйл ажиллагаа явуулдаг Жаргалант суман дах УНС, Цээл суман дах УНС, Бүрэн суман дах УНС, Зуунмод суман дах УНС гэсэн 4 салбар хамрагдлаа. Шалгалтаар нийт 1067.8 сая төгрөгийн албан шаардлага, 4 зөвлөмжийг хүргүүлж, албан шаардлагын хэрэгжилтийн хугацаа болоогүй байна.

Дөрөв. Нийцлийн аудитын талаар

Аймгийн аудитын газрын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу ҮАГазрын нэгдсэн удирдамж төлөвлөгөөний дагуу эхний хагас жилд 3 нийцлийн аудитыг хийж 259 хүн/өдөр ажиллаа. Нийцлийн аудитаар 48.4 сая төгрөгийн төлбөрийн акт, 1343.2 сая төгрөгийн албан шаардлага бичиж, 10 зөвлөмж өгч, 130.4 сая төгрөгийн үр өгөөж тооцлоо.

4.1. Монгол улсын Ерөнхий аудиторын баталсан нэгдсэн төлөвлөгөө, Аймгийн аудитын газрын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу **“Орон нутгийг хөгжүүлэх сангийн зарцуулалт”** –д аудитыг 2016 оны 02 дугаар сарын 01-нээс 05 дугаар сарын 01-ний хугацаанд хийлээ. Аймаг, сумдын хэмжээнд 2015 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль журамд заасны дагуу 5513.0 сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлэхээр төлөвлөн баталж, хуваарилан гүйцэтгэлээр 5049.3 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуудан, иргэдийн саналыг тусган хэрэгжүүлсэн байна. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж буй ажлуудаас иргэдийн саналаар дэмжигдээгүй, төсөвт өртгийг урьдчилан тооцох, техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөв нь хууль, журмын дагуу гаргаагүй байхад хөрөнгийн эх үүсвэрийг баталдаг зөрчил давтагдсаар байна. ОНХСангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд тавигдах захиалагчийн хяналт, гүйцэтгэгчийн гэрээний хэрэгжилтэд хариуцлага тооцох асуудал хангалтгүй байна. ОНХС-аас хэрэгжсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг шилэн дансны нэгдсэн цахим хуудсаар мэдээлэх ажил хангалтгүй хийгдэж байна.

Аудитын явцад төсөл арга хэмжээний төсөвт өртөг болон худалдан авах ажиллагаа, ажлын гүйцэтгэл, хөрөнгийн данс бүртгэлтэй холбоотой нийт 906.3 сая төгрөгийн зөрчил илэрч, 16.7 сая төгрөгийн акт, 889.6 сая төгрөгийн албан шаардлага бичигдэж, холбогдох байгууллага, албан тушаалтнуудад зөрчлийг арилгах 5 зөвлөмжийг хүргүүлснээс акт, албан шаардлагын хэрэгжих хугацаа болоогүй байгаа боловч 8.0 сая төгрөгийн акт, 141.1 сая төгрөгийн албан шаардлага хэрэгжсэн байна.

4.2. Монгол улсын Ерөнхий аудиторын баталсан нэгдсэн төлөвлөгөө, Аймгийн аудитын газрын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу **“Сонгуулийн мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргах”** –д аудитыг 2016 оны 04 дугаар сарын 20-нээс 04 дугаар сарын 28-ний хугацаанд хийлээ. Үндэсний аудитын газар УИХ-ын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн ирүүлсэн “Сонгуулийн мөрийн хөтөлбөр”-ийг дүгнэхдээ Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт-4000, Төрийн хяналт шалгалтын стандартыг удирдлага болгон Сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль болон “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2016 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2017-2018 оны төсвийн төсөөллийн тухай

хуульд нийцүүлэн дүгнэлт гаргасан. Нийцлийн аудитаар 4 нам, 2 бие даан нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргаж аймгийн сонгуулийн хороонд хүргүүлээ.

4.3. Монгол улсын Ерөнхий аудиторын баталсан нэгдсэн төлөвлөгөө, Аймгийн аудитын газрын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу *“Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”* –д аудитыг 2016 оны 02 дугаар сарын 01-нээс 04 дугаар сарын 30-ний хугацаанд хийлээ.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-т “төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд” гэсэн заалтын дагуу 229 байгууллага, аймгийн ТЕЗ болон орон нутгийн ТЕЗ-ийн 27 байгууллага, нийт 257 байгууллага бүрэн хамрагдсан байна. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-т “төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч байгууллагууд” хамаарна гэж заасанд хамрагдах ААНБайгууллагуудыг шилэн дансны нэгдсэн цахим сүлжээнд байршуулаагүй, хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д “худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг мэдээлнэ” гэснийг 112 байгууллагаас 75 байгууллага буюу 67.3% нь мэдээлээгүй байна. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3-дах заалтын дагуу хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэлийг шилэн дансанд бүрэн байршуулаагүй байна. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй, сахилгын шийтгэл тооцох болон зөрчлийг арилгах албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй, дотоод хяналт хангалтгүй ажилласан байна. Иймд дээрх дүгнэлтүүдийг үндэслэн ажил сайжруулах талаар 5 зөвлөмж хүргүүлж, 2918.8 сая төгрөгийн 4 албан шаардлага бичигдсэн.

Тав. ИТХ-ын хүсэлтээр болон өөрийн санаачлагаар хийсэн аудитын талаар

Аймгийн ИТХ-ын хүсэлтийн дагуу аймгийн аудитын газрын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд “Аймгийн 2016 оны төсвийн орлогын төлөвлөгөөний үндэслэл, биелэлтийн байдал”, “Аймгийн төсвийн болон орон нутгийн хөгжлийн хөрөнгө оруулалтаар 2012-2015 онд хийсэн ажлын үр дүн, шинээр бий болсон үйлдвэр цех, барилга байгууламж бусад хөрөнгийг орон нутгийн өмчид бүртгэж авсан байдал” гэсэн 2 гүйцэтгэлийн аудит, “Аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох, хяналт тавих журмын хэрэгжилт” гэсэн нийцлийн аудитыг сүүлийн хагас жил хийхээр тусгасан. Үүнээс “Аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох, хяналт тавих журмын хэрэгжилт” нийцлийн аудитын төлөвлөгөөг батлан аудитыг эхлүүдээд байна.

Зургаа. Дотоод ажлын талаар

Үндэсний аудитын газрын харьяа аймаг, нийслэлийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор нарын удирдах ажилтны зөвлөлгөөн 3 сарын 4-5-ны өдрүүдэд болсон. Уг зөвлөлгөөний үеэр аймаг, нийслэлийн аудитын газруудын 2015 оны ажлыг дүгнэхэд Төв аймгийн Аудитын газар 2015 оны ажлаараа дэд байрт шалгарсан амжилтыг үзүүлээ.

Мөн МУЕА-ын 2014 оны 376 тоот тушаалаар батлагдсан “Оны шилдэг аудитын тайлан шалгаруулах журмын дагуу аймгийн ТЕЗ-ын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл хийсэн аудитын тайланг УАГ-т хүргүүлсэн нь тусгай байр эзэлсэн байна.

Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан журмын дагуу аймгийн аудитын газрын менежер нь аудитор

шинжээч нартай 2016 оны үр дүнгийн гэрээг байгуулан, эхний хагас жилийн гэрээний биелэлтийг дүгнэлээ. Үр дүнгийн гэрээг дүгнэхэд А үнэлгээтэй 4, В үнэлгээтэй 7 албан хаагч дүгнэгдлээ.

Төв аймгийн аудитын газар нь www.audit.mn веб сайтаар 2016 оны эхний хагас жилд хийсэн бүх аудитын тайлан, дүгнэлтийг байршуулан олон нийтэд мэдээлэл хүргэх арга хэмжээг авч хэрэгжүүллээ. Мөн “Төв аймгийн Аудитын газар” гэсэн facebook хаяг нээж олон нийтэд мэдээллийг ил тод тавьж ажиллаа.

ҮАГ-тай нэгдсэн сүлжээнд холбогдсноор зохион байгуулсан онлайн хуралд бүрэн оролцож, мэдээ тайланг шуурхай хүргэн ажиллаж байна.

Үндэсний аудитын газраас 2014 онд нэвтрүүлж эхэлсэн Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын систем (СТАУС) программыг 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитад бүрэн ашигласан. Орон нутгийн төрийн аудитын байгууллагуудаа манлайлан санхүүгийн аудитад уг программыг ашигласнаар тодорхой хэмжээгээр цаг хугацаа хэмнэж, хянан удирдах үйл ажиллагааны арга зүйг стандартын дагуу хэрэгжүүллээ.

Аймгийн аудитын газрын албан тушаалтнуудаас хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэгийг гаргуулан авч, ХОМ-ийн тайланг Авлигатай тэмцэх тухай хуулийн дагуу 02 дугаар сарын 15-ны дотор ҮАГ-т хүргүүлсэн.

2016 оны эхний хагас жилд иргэдээс 4 өргөдөл, санал хүсэлт ирүүлснийг хуулийн хугацаанд шалган хариуг албан ёсоор хүргүүлээ.

Үндэсний аудитын газраас ирүүлсэн албан бичгүүдийн дагуу шаардлагатай судалгааг хугацаанд гаргаж хүргүүлж ажиллаа.

Улирал бүр статистик мэдээ гарган аймгийн Статистикийн хэлтэст, хагас жилээр статистик мэдээ, үйл ажиллагааны тайлан гарган ҮАГ-аар хүргүүлэн ажиллаа.

252 санхүүгийн тайлангийн аудит, 3 гүйцэтгэлийн аудит, 3 нийцлийн аудит, 16 завсрын аудитын үе шат бүрт чанарын хяналтыг хийж, чанарын хяналтын хуудсыг хөтөллөө. Гэрээт аудитын компаниудын санхүүгийн аудит, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хуулийн үндэслэлд хяналт тавьж ажиллаа. Аудитын тайланг хувиалан олшруулж 286 албан тушаалтанд олгож, аймгийн аудитын газрын үйл ажиллагааны талаар Тэргүүлэх аудитор 4 байгууллагад очиж мэдээлэл хийсэн байна.

Авилгын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан мөрдөж ажиллаж байна. Мөн аудит эхлэх бүрд ашиг сонирхолын зөрчилгүй тухай мэдэгдэлд аудитор, шинжээч нараар гарын үсэг зуруулж баталгаажуулж, программд шивж байна.

СТАУС программыг ашиглах, өөрчлөлт тохируулгын ажлын талаар Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ж.Батсайхан, SMART GREEN ХХК-ны захирал Одхүү нар Төв аймгийн Аудитын газрын ажилтнуудад сургалтыг 2016 оны 01 дүгээр сарын 06-ний өдөр явууллаа. Уг сургалтаар программын сайжруулалтын талаар харилцан ярилцлаа.

Үндэсний аудитын газраас нэгдсэн сүлжээнд холбогдсноор “Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалт”, “Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын дүнгийн талаар”, “Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн”, “Нэгдсэн төсвийн гүйцэтгэл”, “Сонгуулийн мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргах”, “Сонгуулийн зардлын дээд хэмжээ тогтоох”, “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт” зэрэг аудитын явц, дүнгийн талаарх мэдээлэл солилцох онлайн хурал, сургалтанд давхардсан тоогоор 29 ажилтан хамрагдлаа.

Аудитын газрын менежер, шинжээч, нягтлан бодогч нар 4-р сард аймгийн ЗДТГазраас зохион байгуулсан Захиргааны ерөнхий хууль, Авлигын эсрэг хууль, Ашиг сонирхлын зөрчлийн эсрэг хууль болон 2015-2016 онуудад шинээр батлагдсан хуулиудын талаар 2 өдрийн сургалтанд хамрагдав.

Үндэсний аудитын газраас 2016.06.22-ны өдөр зохион байгуулсан “Аудитад мэдээллийн технологийг ашиглах, хөгжүүлэх зарим асуудал” сэдэвт хэлэлцүүлэгт Төв аймгийн аудитын газрынхан бүрэн бүрэлдэхүүнээрээ ороцлоо. Хэлэлцүүлгийн үер “Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системийг турших, үйл ажиллагаанд

нэвтрүүлэхэд орон нутагт тулгарч байгаа асуудал, шийдвэрлэх арга зам”-ын талаар Төв аймгийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Л.Жаргалсайхан илтгэл тавилаа.

Төв аймгийн Аудитын газрын хамт олон Дорнод аймгийн Аудитын газарт 2016.05.16-нд очиж, тус байгууллагын туршлага судаллаа. Мөн Говьсүмбэр аймгийн Аудитын газрынхан 2016.06.24-ны өдөр Төв аймгийн Аудитын газарт ирж туршлага солилцлоо. Орон нутагт хийгдэж буй санхүү, гүйцэтгэл, нийцлийн аудит болон дотоод ажил, сургалт, чанарын хяналт гэсэн чиглэлээр харилцан ярилцаж туршлага солилцлоо. Энэ үеэр волейболын нөхөрсөг тоглолт зохион байгууллаа.

2016 оны 4 сард Аймгийн Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Л.Жаргалсайхан төрийн дээд шагнал “алтан гадас” одон, Ахлах аудитор Т.Майцэцэг “Хөдөлмөрийн хүндэт медаль”-иар шагнагдлаа.

Долоо. Санхүүгийн тайлагнал, төсвийн гүйцэтгэл

2016 оны эхний хагас жилийн байдлаар 141.2 сая төгрөг батлагдсанаас сар бүрийн хуваарийн дагуу 141.2 сая төгрөгийн санхүүжилт авч, цалин шимтгэлд 115.9 сая төгрөг, хангамжийн материалд 6.1 сая төгрөг, томилолт 4.0 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил буюу үйлчилгээний ажилчдын цалин, бусад татвар хураамжид 9.0 сая төгрөг бусад зардалд 0.4 сая төгрөг нийт 136.0 сая төгрөг зарцуулаад байна. Төсвийн үлдэгдэл 5.6 сая төгрөг холбогдох зардлуудад хүлээгдэж байна. Мөн орон нутгаас авто машин авах дэмжлэг 30.0 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн нь үлдэгдэлээр тайлагнагдсан байна. Урьд оны татварын өглөг 1.0 сая төгрөгнөөс 0.3 сая төгрөгийг барагдуулсан.

Байгууллагын санхүүгийн сар бүрийн мэдээг дараа сарын 2-ны дотор, хагас жилийн тайланг дараа сарын 20-ны дотор дээд шатны байгууллагад хүргүүлэн баталгаажуулан нэгтгүүлж байна. Байгууллагын санхүүгийн мэдээллийг хуулийн хугацаанд Шилэн дансны нэгдсэн вэб сайт болон Үндэсний аудитын газрын вэб сайт, байгууллагын самбарт мэдээллэж ажиллаа.

Найм. Дүгнэлт санал

Төв аймгийн Аудитын газар нь 2016 оны аудитын болон үйл ажиллагааны төлөвлөгөөг 7 бүлэг 44 хэрэгжүүлэх арга хэмжээтэйгээр боловсруулан баталсанаас эхний хагас жилд хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг бүрэн хэрэгжүүллээ. 14 үндсэн орон тоо батлагдсаны дагуу нийт 1256 хүн/өдөр ажилласан байна.

2016 оны эхний хагас жилийн байдлаар батлагдсан төлөвлөгөөний дагуу 141.2 сая төгрөгийн санхүүжилт авч үйл ажиллагаагаа хэвийн явууллаа.

Эхний хагас жилд 3 гүйцэтгэлийн аудит, 3 нийцлийн аудит, 280 санхүүгийн аудитыг хийж, 37250.2 сая төгрөгийн зөрчил илэрүүлж, 10870.2 сая төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулж, 634.8 сая төгрөгийн төлбөрийн акт, 17303.8 сая төгрөгийн албан шаардлага бичиж, 514 зөвлөмж өгч, 117.3 сая төгрөгийг орон нутгийн төсөвт орууллаа. Актын барагдуулалт 21.8 хувийн биелэлттэй, албан шаардлагын хэрэгжилт 70.1 хувийн биелэлттэй байна.

Нийт санхүүгийн үр өгөөж 1978.0 сая төгрөг бүртгэж, харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрөгдсөн санхүүгийн үр өгөөж нь 586.7 сая төгрөг байна.

МУЕА-ын 2016 оны төсвийн багцад автомашин худалдан авахад батлагдсан хөрөнгийн хуваарьт манай байгууллагад 25.0 сая төгрөг тусгагдсан, дээр нь аймгийн ИТХурлаар шийдвэр гаргуулан 30.0 төгрөгийн эх үүсвэр шийдвэрлүүлээд байна.

Төв аймгийн Аудитын газар нь үндсэн 12, туслах 2 нийт 14 орон тоотой үйл ажиллагаа явуулж байгаагаас туслах 2 ажилтны цалин сар бүр батлагдсан төсвийн

хуваарийн дагуу санхүүжигдэхгүй байгаагаас өр, авлага үүсч хүндрэл учирч байна. Иймд 2 ажилтны цалингийн санхүүжилтийг үндсэн ажилтны цалингийн санхүүжилттэй цуг хийж байх талаар анхаарч тусалж өгнө үү.

САЙН ҮЙЛС ДЭЛГЭРЭХ БОЛТУГАЙ

*ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬАА
ТӨВ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР*